

Ja'ud-quri ~ *Ca'ud-quri* хэмээх цолын учир
холбогдолд нэмэрлэх санал

Ц. Шагдарсүрэн*

0. Оршил

I. *Ja'ud-* ~ *Ca'ud-* хэмээх үгийн тухай

- I. 1. Монгол хэлний холбогдох баримт хэрэгтэгдэхүүн
- I. 1. 1. “*Монголын нууц товчоон*”...
- I. 1. 2. “*Ииа-үи Үи-ий*”...
- I. 1. 3. “*Алтан товч*”, “*Хураангуй Алтан товч*”...
- I. 1. 4. Монгол хэл аялгууны холбогдох үг хэлэлгэ
- I. 1. 5. Хяган хэлний: *ch'ao-wi-erh*
- I. 1. 6. Бурханы “*Арван хоёр зохионсуй*”... ?
- I. 2. Зөрчид хэлний холбогдох баримт хэрэгтэгдэхүүн
- I. 3. Манж хэлний холбогдох баримт хэрэгтэгдэхүүн
- I. 4. Нэгдүгээр хэсэгийн дүгнэлт

II. *-quri* хэмээх үгийн тухай

- II. 1. Зөрчид хэлний холбогдох хэрэгтэгдэхүүн
- II. 2. Монгол хэлний үүдгээс авч үзэх нь

Ерөнхий дүгнэлт таамаг

0. “*Монголын нууц товчоон*”-ны 134-р зүйлд Зөрчидийн Алтан улс (1115-1234)-аас Чингис хааны гавъяа зүтгэлийг үнэлэж “...*C'inggis qahan-a Ja'ut-quri nere ökba.*” (§134 L. 3628) хэмээн өгүүлжээ.¹ Энэхүү *Ja'ut-quri* цолыг уг номын 179-р зүйлд “...*uyidangqa ke'ekde üjü ta ca'ut-quri-yin turuq ele aju'ai*...” (179. L. 6114) хэмээн² арай өөрөөр *Ca'ut-quri* гэж тэмдэглэсэн нь буй ч утгын хувьд ялгаатай гэж үзэх үндэс байхгүй (энэ тухай хойно товч өгүүлэх болно). Тэгээд ч И. дө Рахевилз профессор “*Монголын нууц товчоон*”-ы үгийн хэлхээндээ уг хоёр үгийг нэгэн толгойд салбарлуулан багтаажээ. Энэхүү цолыг эрдэмтэд хэрхин галигласан байдалыг харахад эхиний хэсэгийг *Jaud...* ~ *Ja'ut...* / *Ca'ud...* ~ *Ca'ut...* хэмээсэн байх боловч “*Монголын нууц товчоон*”-ы бүр анхны уг эх нь монгол бичигээр байсан. түүнээс нь

* Монгол Улсын Их Сургууль, *Монгол Судлалын Тов*

¹ Igor de Rachewiltz. *Index to the Secret History of the Mongols*. - Uralic and Altaic Series (Indiana University), Vol. 121. Bloomington, 1972, p. 57 [L: 3528].

² Igor de Rachewiltz. *Index to the Secret History of the Mongols*. - Uralic and Altaic Series (Indiana University), Vol. 121. Bloomington, 1972, p. 91 [L: 6114].

хятад галигаар буулгасан болох нь олон зүйлээр батлагдаж буй тул монгол хэлний дэвисхэр гийгүүлэгчийн хуулиар *Jaud...* / *Ca'ud...* гэх нь илүү зохистой буй заа гэж санана. Рашид Ад-дин “*Сударын чуулган*”-даа “*жаут хүри буюу хятадаар агуу их ноён*” гэсэн үг хэмээсэн¹ байх боловч зөв эсэх нь тодорхойгүй. Мөн 134-р зүйлд, *Jaud...* / *Ca'ud...* гэдэгтэй дуудалга ойр *jau-tau* [*jeutau*]² гэдэг бас нэгэн цолын нэр гардаг. Нэгэнт уг эхэд тэрхүү цолыг *Ca'ud-quri* -гээ зэрэг дэв дээгүүр хэмээн тодорхой дуралсан байх тул *Ca'ud(-quri)*, *Jau-tau* хоёрыг алин гэж үзэх аргагүй боловч зарим судлагчид холбон тайлбарласан нь төдий л оновчтой бус буй заа. Нэрт монголч эрдэмтэд, тухайлбал: нангиадач-монголч П. Пеллио (P. Pelliot), академич Б. Я. Владимирцов, нангиадач-монголч Ф. В. Кливез (F. W. Cleaves), түүхч П. Рачневски (P. Ratchnevski) нар тэр хоёр цолын утга учирьг тайлбарлажээ. *Ca'ud-quri* хэмээх цолын тухайд, “*Чингис хаан*” хэмээх бүтээлдээ Б. Я. Владимирцов “*хил хязгаарыг сахих цэрэгийн дарга*” (chef militaire garde-frontière) хэмээсэн нэн даруухан цол (le titre plus modeste) гэсэн ахул мөн тийм нэгэн нэр бүхий зохиолдоо П. Рачневски профессор “бага зиндааны цол” хэмээн тодложээ.³ Ф. В. Кливез авгай энэхүү цолын талаар тухайлан тайлбарлаагүй боловч ногоохи *Jau-tau* гэдэгийг нь Сүнгийн “*chao-l'ao*” гэдэг цолоос үүдэлтэй, тэр нь “*түвшиндхэх комиссар*” (pacification commissioner) гэсэн утгатай хэмээжүхүй.⁴

Говч Сүн улстай илэрхий зөрчилдөж байсан Алтан улс, Сүн улстай найртай бус харьцаатай байсан монголын нөлөөтэй язгууртанд цэрэгийн гавъяа зүтгэлийг нь үнэлэж Сүн Улсын багашааргахан цол шагнана гэдэг нь учир шалтгааны үүднээс эрхгүй эргэлзээ төрүүлнэ. Иймэд Зөрчидийн Алтан улсаас 1196 оны зун татаар (буюу *цубу*)⁵ нарыг)-ыг дарахад байгуулсан гавъяаг нь үнэлэж Чингис хаантанд хүртээсэн энэхүү цолын утга учир, гарал үүсэлийг хэлний талаас, ялангуяа зөрчид хэлний холбогдох хэрэглэгдэхүүнтэй харьцуулан судлаж гэмээ нь олон зүйл тодрох нь магадтай боловч энэ хэр тийнхүү хангалттай тайлбарлаж нэгэн мөр болгосон зүйл бас үгүй. Ер нь “*Монголын нууц товчоон*”-оо утга тодорхойгүй, зохих тайлбар шаардсан үг олон, зарим тийм үгийн талаархи судлагаа хэд хэдээрээ гарсан нь ч буй.

Үүнтэй харьцуулан үзвэл бидний сэдэв болгож буй үгийн талаархи тусхайлсан судлагаа тийм ч олон биш, баруун дахинд бараг гараагүй ажээ. Гэхэдээ “*Монголын нууц товчоон*”-ыг судласан орон ороны эрдэмтэд уг нэр томъёог анхааран зарим нь судлагааныхаа ташрамд саналаа дэвшүүлсэн нь буй. Харин БНХАУ-ын судлагчид энэхүү цолыг монгол хэлний талаас үзсэн нь түүхүү харагддаг бөгөөд эрдэмтэн Хох-өндөр тэдгээр судлагааг нэгдхэн дүгнэхэд *Ca'ud-quri* хэмээх цол нь “*зудын ноён*” гэдэг саналыг зөвшөөрөн толилуулан тусхай өгүүлэл нийтлүүлсэн байна.⁶ И. дө Рахевилз профессор ч *Ca'ud-quri* цолыг “Kommander of Hundreds (?)” гэж эргэлзэнгүй, *Jau-tau* [1972: *jeu-tau* > 2004: *jau-tau*] цолыг “*pacification commissioner*” хэмээн англи орчуулгаар ялган талбарласан нь түрүү түрүүчийн эрдэмтэдийн

¹ Рашид Ад-дин, *Сударын чуулган*, 1-р боть, Ц. Сүрэнхорлоогийн орчуулга, Улаанбаатар, 2002, 244-р тал.

² Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, - Uralic and Altaic Series (Indiana University), Vol. 121, Bloomington, 1972, pp. 56 [L: 3633], 248.

³ В. Vladimirtsov, *Genghis-Khan*, Paris, 1948, [160 pp], p. 37; Пауль Рачневский, Чингис хаан, түүний амьдрал оюу, Улаанбаатар, 2006, [216 тал], 37, 166, 202-р тал.

⁴ F. W. Cleaves, *The secret History of the Mongols*, Harvard, Cambridge, London, 1982, [277p.], p. 63.

⁵ М. В. Воробьев, *Чжурчжэни и государство Цзинь*, Москва, 1975 [448 стр], стр. 123; Feng Ch'eng-chün, *The Peoples and Tribes on the Northern Frontier of Liao and Chin*, - Fujen hsüehchih (series sinologica), vol. VIII, N. 1, Peiping (1913).

⁶ Хох-өндөр, 札兀惕忽里 гэдэг үгний утгын тухай, - Өвөр Монголын Нийгэмийн шинжлэх ухаан, 1993 оны нэгдүгээр хугацаа, No. 62, 87-91-р тал (монгол бичигээр).

судлагааг харгалзсан хэрэг буюу.⁹

Ингээд уг цолыг зөрчид хэлний баримт сэлтэд тулгуурлаж, төрөл монгол хэл, аялгууны холбогдох хэрэглэгдэхүүнтэй харьцуулсан судлагаагаа толилуулсу.

I. Ja'ud- ~ Ca'ud- хэмээх үгийн тухай

I.0. Иймэд эл өгүүлэлийнхээ эхний хэсэгт Зөрчидийн Алтан Улсаас хүртээсэн *Ja'ud-quri* (札兀惕忽里) ~ *Ca'ud-quri* (察兀惕忽里)¹⁰ хэмээх цолын *Ja'ud- ~ Ca'ud-* гэдэг эхний хэсгийн утга учирьг тодруулах зорилгоор Алтай овогийн монгол болон зөрчид хэл, түүнтэй шууд холбоо бүхий манж хэлний хэрэглэгдэхүүнийг харгалзан уг үгийн утга учирьг тодруулах гэж чармайв. Үүнээс өмнө миний бие монгол хэлний хөгжилийн эртний үе, Алтай хэлний харьцуулсан судлагааны аргазүйн талаар бичсэн хэд хэдэн бүтээлдээ энэ талаархи холбогдох ажиглалтаа хэсэг бусаг толилуулж¹¹ ирсэнээс гадна тусхайлан нэг өгүүлэл бичихээ амласан бөгөөд одоо тэр амлалтаа ёсоор болгож буй минь энэ.

I. 1. Монгол хэлний холбогдох баримт хэрэглэгдэхүүн:

Монгол бичигийн дурасхал болон монгол хэлний нутаг нутагийн аялгууны хэрэглэгдэхүүнийг шүүрдэн үзвэл бидний судлагдахуунд шууд холбогдох олон зүйл баримт гарч ирнэ. Үүнд:

I. 1. 1. “Монголын нууц товчоон”-д бидний судлагдахуун болж буй *Ja'ut-quri* (§134 L. 3628) - *Ca'ut-quri* (§ 134, L. 3628)¹² хэмээх цол хийгээд түүнтэй язгуур гарал нэг гэж үзэж болохуйц нэр үг *ca'ur* [(§ 254, L. 10233), (§ 255, L. 10513)], мөн үйл үг *ca'ura-* нь:

ca'uraju [(§ 236, L. 9302), (§ 255, L. 10513)],

ca'uran [(§ 254, L. 10233)],

ca'ura'ulba [(§ 199, L. 7434*), (§ 202, L. 7710*), (§ 235, L. 9235), (§ 240, L. 9405)]

гэдэг хэлзүйн хэлбэрээр тус тус тохиолдож байна. Тохиолдол бүрийг холбогдох жишгээтэй нь танилцуулбал утга санаа нь юу болохыг ойлгоход үлэмж дөхөм болох буй заа.

⁹ Igor de Rachewiltz, *The Secret History of the Mongols*, Translation, Historical and Philological commentary, Vol. 1-2, Leiden-Boston, 2004, [pp. i-cxxvi + 6 + 1-642 + 643-1347], pp. 57, 58.

¹⁰ Дээр эш татсан гол хэрэглэгдэхүүнийг проф И. Дө Рахевилз авгайн 1972 оны хэвлэлээс авсан бөгөөд тэнд монгол бичигийн хэлний галигт *č*-ээр тэмдэглэдэг үсэгийг *c* хэмээсэн байх тул тэр хэвээр нь авсан болно. Ниймэд энэхүү өгүүлэлд *č*, *c* хоёрыг хольж будилсан мэт харагдаж байгаа ч чухамдаа *č = c* гэж ойлгохыг хүсье. Ингэлээ гээд энэ тохиолдолд утга санаа самуурах зүйл үгүй.

¹¹ Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - *Mongolian Studies* (The Korean Association for Mongol Studies), N. 6 (1998), Seoul, 1999, pp. 61-139; Нэмэн зассан хоёлдугаар хэвлэл: Ц. Шагдарсүрэн, *Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судласан тойм*, - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэлн: Монгол хэл, II дэвтэр), Улаанбаатар, 1999, 67-125-р тал; Ts. Shagdarstüring, *Problems of Methodology of Altaic Comparative Linguistics*, - *Rocznik Orientalistyczny*, Tom. LVIII, Zeszyt 1 (Opera Altaistica professori Stanislawo Kaluzyński octogenario dicata), Warszawa, 2005, pp. 179-187.

¹² Дээр өгүүлэчинийг холбогдох эшлэлийг И. Дө Рахевилз авгайн бүтээлээс шууд авсан тул байгаагаар нь буюу *Ja'ut-quri ~ Ca'ut-quri* хэмээн *-t* -тэй авсан болно.

ca'ur :

...urtu ca'ur ca'uran ... (§ 254, L. 10233),

...urtu ca'ur ca'uraju ... (§ 255 L. 10513);

ca'ura- > ca'uraju ... :

...neken ca'uraju... (§ 236, L. 9302),

...urtu ca'ur ca'uraju ... (§ 255, L. 10513);

ca'ura- > ca'uran ... :

...urtu ca'ur ca'uran... (§ 254, L. 10233);

ca'ura- > ca'ura'ulba ... :

...hüker jil ca'ura'ulba (§ 199, L. 7434*),

...neke 'ülen tende gü ca'ura'ulba (§ 202, L. 7710*),

...qubilai noyan-i qarlu'ut-tur ca'ura'ulba (§ 235, L. 9235).

...qori-tumat irgen-tür ca'ura'ulba (§ 240, 9405)

Эдгээр жишээнээс үзэхүл уг үг нь “*довтло/х, дайра/х, цэрэглэ/х*” гэсэн шууд утгатай, үүнээс үүдүүлэн “*дайчин, эрэлхэг, зориг*” хэмээсэн шилжимэл утга үүссэн гэж үзэхэд эргэлтээ гөрөхөөргүй бөлгөө.

“*Монголын нууц товчоон*”-ы энэ үг уг сурвалжийг судласан орчуулсан бүх эрдэмтэдийн анхааралыг багагүй татаж байсан нь бэлээхэнээ харагддаг. Н. Поппе (N. Poppe)¹³, И. До Рахевилз (Igor de Rachewiltz) нарын судлагаанаас үзвэл: *ca'ur* ‘*campaign*’, *ca'ura-* ‘*to go on a campaign*’¹⁴ гэж орчуулсан байна. Ф. В. Кливез (F. W. Cleaves) авгай уг үгийг мөн тэгэж, зарим тохиолдолд арай дэлгэрүүлэн ‘*military camjaign*’ гэж тодруулан орчуулсанаас гадна бас *ca'ur* ‘*warfare*’, *ca'ura-* ‘*to go a warfare*’ хэмээсэн нь гол утгын хувьд онцын ялгаа байхгүй гэж үзэж болно.¹⁵

Энэ мэтээр “*Монголын нууц товчоон*”-ы франц, орос, герман зэрэг бусад хэлээрхи орчуулгалд тухайлбал: францаар *ca'ur* ‘*campagne militaire, long campagne*’, *ca'ura-* ‘*expédier en campagne militaire, entreprendre une longue campagne*’, оросоор *ca'ur* ‘*поход*’ гэх мэтээр орчуулсан¹⁶ нь тухайн хоёр үгийн талаархи монголч эрдэмтэдийн ойлголт нэгэдмэл болохыг харуулж байгаа хэрэг.

¹³ N. Poppe, *On Some Military Terms in the Yuan-ch'ao pi-shih.*- Monumenta Serica, 26, 1967, pp. 506-517.

¹⁴ Igor de Rachewiltz, *The Secret History of the Mongols*, Translation, Historical and Philological commentary, Vol. 1-2, Leiden-Boston, 2004, [pp. i-cxxvi + 6 + 1-642 + 643-1347], p. 762.

¹⁵ F. W. Cleaves, *The Secret History of the Mongols*, Volume I, London, 1982, [277 p.], pp. 135, 189; F. W. Cleaves, *The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-jüi* - Harvard Journal of Asian Studies 13: 1950, pp. 1-131; Igor de Rachewiltz, *The Secret History of the Mongols*, Translation, Historical and Philological commentary, Vol. 1-2, Leiden-Boston, 2004, [pp. 3-642 + 643-1347], p. 925.

¹⁶ Marie-Dominique Even, Rodica Pop, *Histoire secrète des Mongols*, Gallimard, Paris, 1994, [229 pp.], pp. 166, 218; Сокровенное сказание Монголов, Перевод С. А. Козина, Улан-Удэ, 1990, стр. 96.

“Монголын нууц товчоон”-ыг судлаж орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлсэн Монголын эрдэмтэдийн тухайд бидний судлагдахуун болж буй үгийн тухайд цол нэрээс бусад тохиолдолд *ca'ur*, *ca'ura*-, *ca'ura'ul*- гэх зэрэг үгийн хэлзүйн хэлбэрийг нэгэн зарим нь орхиод, утгачилаж өөр үгээр сольсон (Ц. Дамдинсүрэн), зарим нь уг үгийг хаалтанд хийж мөн өөр үг хэрэглэн тайлбарласан (Д. Цэрэнсодном), нөгөө зарим нь уг хэвээр нь хэрэглэж тайлбарласан (Ш. Чоймаа) байдал харагдана. Монголчуудын уугуул бүтээлд байгаа монгол үгийг, өнөөдөрийн хэмжүүрээр утга нь бүдгэрсэн хэмээн оорч орхих нь монгол хэлний хувьд ч, эхбичиг судлалын хувьд ч төдий л сайшаагаад байх зүйл биш гэдэгийг энэ далимд тэмдэглэе. Тэр тоолонгоор монгол хэлний үгийн сангаас тухайн үг хасагдахад хүрнэ гэсэн үг. Утга бүдэг, хэрэглээ хязгаартай болсон боловч энэ мэтийн үгийг тайлбарлан хэрэглэж гэмээ нь наад зах нь олон нийтэд ийм нэг үг, хэлэлгэ байсан юм байна шүү гэж мэдрүүлэх нь монгол хүндээ ч, монгол хэлэндээ ч хэрэгтэй бөлгөө. Үгийн утга учирыг зөв ойлгуулахыг эрмэлзэх нь зүйтэй ч, түүгээр түрий барин ганц үгээр ч болов үгийн сангаа дундлахгүй байх нь монгол хэл хийгээд монгол үндэстэний ирээдүйтэй шууд холбоотой ...

I. 1. 2. “Монголын нууц товчоон”-ы нэгэн адил, дундад үеийн монгол хэлний дорнод аялгууны дурасхал болох монгол үгийг хятадаар галиглан тэмдэглэсэн олон зүйл “*Yi-ii*” маягийн толийн нэг болох “*Hua-yi Yi-ii*” толийн хавсралт дахи бичивэрт “...*nidöni hon ča'uraqui-tur*...” (“...*ноднин жил чаурахуйд...*”) гэсэн үг буй бөгөөд¹⁷ Х. Курибаяши энэ хэсэгийг “...*nidöni hon čawura=qui-tur*...” хэмээн галигласан нь уг тольд буй *ča'ud* [*<Mo. čaγ-ud*] гэдэг үгээс дуудалга салгах гэсэн хэрэг болов уу [*1-р хавсралтыг үзнэ үү!*].¹⁸

Монголч эрдэмтэн А. Мостарт авгай энэхүү *ča'ura*- (хятад галигаар: *ch'ao-wu-erh*) гэдэг үгийг францаар *faire un campagne* (дайла-, довтоло-, цэрэглэ-) гэж орчуулаад дээрхи хэлэлгийг *L'an dernier, lors de la campagne* хэмээн франц болгожээ.¹⁹ Энэ бүхэнээс үзвэл бидний судлагдахуун болж буй үг тухайн цагтаа өргөн хэрэглэгдэж байсан монгол үг болох нь тодорхой харагдана.

I. 1. 3. Лувсанданзаны “*Алтан товч*”-ын гар бичимэл эхийн 85. б. хуудаснаа “...*Qubilai noyan-i Qarluyud-tur čaγurayulbai*...” гэсэн хэсэг буй.²⁰ Сурвалжийн уг эхийг үзвэл утга тодорхойгүй олон үгэнд тодлосон тайлбар хадсанчилан тэрхүү *čaγurayulbai* гэдэгийн өмнө нь *čeriglegülbei* гэдэг үгийг нэмэн тодложээ [*2-р хавсралтыг үзнэ үү!*]. Энэ нь тухайн үед уг үгийн хэрэглээ олон нийтийн дунд саарсан боловч бичигийн хүмүүсийн хувьд утга нь тодорхой байсаныг давхар гэрчилэнэ.

“*Хаадын үндсэн хураангуй Алтан товч*”-д бидний сонирхол татаж болохуйц нэг нэр буй нь:
...*Ariγ Senggirčesgaba glubum čaurčā*...

¹⁷ A. Mostaert, *Le Materiel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*, I, par Igor de Rachewiltz, Bruxelles, 1977, pp. 13, 46; A. Mostaert, *Le Materiel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*, II (Commentaires), par A. Mostaert et Igor de Rachewiltz, Bruxelles, 1995, p. 110.

¹⁸ Hitoshi Kuribayashi, *Word- and Suffix-Index to Hua-yi Yi-yü...*, Tohoku University, Sendai, 2003, pp. 110, 126.

¹⁹ A. Mostaert, *Le Materiel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*, I, par Igor de Rachewiltz, Bruxelles, 1977, pp. 13, 46; A. Mostaert, *Le Materiel mongol du Houa I I lu de Houng-ou (1389)*, II (Commentaires), par A. Mostaert et Igor de Rachewiltz, Bruxelles, 1995, p. 110.

²⁰ *Altan tobči*, (Гэрэл зурагийн хуулбар хэвлэл) Ulaγanbayatur, 1990, 85. б, 13-14-р мөр; (Hans-Peter Vietze, *Gen-deng Lubsang*); *Altan Tobči*, Tokyo, 1992, ss. 61, (Cf. 85.b. 2686-2687).

бөгөөд түүнийг уг сурвалжид Шарайгур улсын *баатар* хэмээн тодлосон нь ямар ч атугай баатар идэрхэг дайчин эр гэсэн утга бүхий нэр байхыг үгүйсгэх аргагүй.²¹

I. 1. 4. Монгол хэлнээ “*цэрэг цуух*” гэдэг холбоо үг бий. Үүний “*цуух*”-ыг манжийн “*цэрэг*” гэсэн үг хэмээн үздэг нь зүйтэй буй заа. Монгол хэлнээ энэ мэтээр монгол үг, түүнтэй утга дүйх харь үгээс бүтсэн жишээ нь “*үйл лай*” гэх зэрэг холбоо үг олон буй. Манжийн нөлөө үлэмж болсон үеэс монгол хэлнээ хэрэглэгдэх болсон “*Цэрэг цуух*” гэдэг үг энэ ёсоор буй болсон нь маргаангүй ч манж хэлний “*цуух*” (< Ma. *ᠴооха*) гэдэг үгийн гарал үүсэлийг авч үзэх бөгөөс түүнтэй нэг язгуураас салбарлан хөгжсөн монгол үгийн хэлбэр байсан гэж үзэх үндэс буй.

Монгол хэлний нутаг нутагийн аялгуунд, тухайлбал: халх, буриад, ордосын аялгуу болон хятан хэлний баримтад бидний судлагдахуунтай язгуур нэг бөгөөд зэргэд хөгжисөөр байсан гэж үзэхээр үг хэлэлгэ буй. Үүнд: халхын аялгуунд одоо хүртэл “*буу цоор*”, “*буу цоор болсон олон хүн явна*”, “*буу цоор гаргах*”, “*буу цоортоо хүрэх*” гэх зэрэг хэлэлгэ буй. Эндээс тухайн хэлэлгэ “*цэрэг зэвсэг*”-тэй холбоотой болох нь тодорхой. Халхын аялгууны “*цоор*” гэдэг үг нь ордосын аялгуунд “*ts'irik ts'ür*” гэдэг хэлэлгэд, буриадын аялгуунд “*сэрэг суур*” гэдэг хэлэлгэд тус тус байгааг А. Мостаер (A. Mostaert), Н. Поппе (N. Poppe) нарын судлагаа болон буриад хэлний толь бичигүүд ч давхар батлаж байна.²²

Үүгээр үл барам А. Мостаер (A. Mostaert) авгай ордос аялгууны *ts'ür* гэдэг үгийг “*Ордос толь*” бичигтээ “*Монголын нууц товчоон*”-ы *ca'ur* гэдэгтэй шууд холбон тайлбарлаад францаар ‘*expédition militaire*’ буюу ‘*дайлаар мордох, цэрэглэх*’ хэмээн орчуулжээ.²³ Орчин цагийн монгол хэлний энэхүү үгийн гаралыг сөхөөн сэргээнэ гэвэл А. Мостаер (A. Mostaert) авгайн үзсэнчилэн Дундад үеийн монгол хэлний дурасхал болох “*Монголын нууц товчоон*”-дахи мөнөөхи *ca'ur* гэдэг үгтэй холбохоос өөр замгүй бөгөөд өдгөөгийн халхын аялгууны ‘*цоор*’, ордосын аялгууны ‘*ts'ür*’, буриад аялгууны ‘*суур*’ нь монгол бичигийн хэлний Мо. **ᠴаγи+r*–аас салбарласан хөгжилийн өнөөгийн үр дүн гэж үзэх бүрэн үндэс буй.

I. 1. 5. Үүний дээр хятад сурвалжид ханз үсэгээр галигласан хятан хэлний баримтад *ch'ao-wu-erh* буюу “*тулалда/х, дайлалда/х, тэмцэлдэ/х*” гэсэн утга бүхий *caowur* гэдэг үг тэмдэглэгдэн үлдсэнийг эрдэмтэд²⁴ дээрхи язгууртай холбон үзсэнтэй бид санал нэг байна.

I. 1. 6. Нэгэн зүйл: 2006 онд Тайбэй хотноо хэвлүүлсэн академич Д. Төмөргогоогийн XIII – XVI зууны монгол бичигийн дурасхалын эхбичигийн судлагаанаас үзвэл Бурханы “*Арван хоёр зохионгуй*”-д:

²¹ Ш. Чоймаа, *Qad-un ündüsün quriyanguui altan tobči*, Monumenta Mongolica (Centre for Mongol Studies, National University of Mongolia), Tomus II, Улаанбаатар, 2002, [331 pp.] 104. a (81b. 06), 129 (N. 896)-тал.

²² A. Mostaert, *Dictionnaire ordos*, seconde édition, New-York – London, 1968, p. 719. a.; N. Poppe, *Ancient Mongolian*, -Tractata Altaica, Wiesbaden, 1976, p.463 [Second (Photo) edition in Ulaanbaatar: Эртний монгол хэлний судлал, - Selected Materials for Mongol Studies, Series I : Mongolian language and scripts, vol. 2, Edited by J. Batiredui, Ts. Shagdarsuren, Ulaanbaatar, 1999, pp. 7-22]; К. М. Чермисов, *Буриад-орд словарь. Бурятско-русский словарь*, Москва, 1973, стр. 397.а, 404. а.

²³ A. Mostaert, *Dictionnaire ordos*, seconde édition, New-York – London, 1968, p. 719. a.

²⁴ N. Poppe, *Ancient Mongolian*, -Tractata Altaica, Wiesbaden, 1976, p.463 [See Footnote 5: Karl H. Menges, *History of Chinese Society*: Liao (907-1125) – Transactions of the American Philosophical Society Held at Philadelphia, New Series, vol. 36, (1946), p. 433; N. Poppe, *On Some Military Terms in the Yuan-ch'ao pi-shih*, - Monumenta Serica, 26, 1967, p. 512.].

“...adalidqaba:su čayu:rayu:lči-yin orčiyu:lqui kürdiin metü...”

хэмээсэн хэсэг буй ажээ.²⁵ Гадаад хэлбэрээрээ бидний анхааралыг татсан энэ хэсэгийг Н. Поппе авгайн “*Арван хоёр зохионгуй*”-н судлагаа, тайлбар, англи орчуулгатай харьцуулан үзэхүл, дээрхи čayu:rayu:lči гэдэг үгийг čaqurayulči хэмээн галиглаад дээр эш татсан хэсэгийг бүхэлд нь англиар “...for example, like the wheel turned by a potter [‘ваарчин’]...” гэж орчуулахдаа “*Ганжуур*” (Kanjur, fol. 128r – 128v) дахи “*Арван хоёр зохионгуй*”-н холбогдох хэсэгтэй давхар жишиж тайлбарласан байна.²⁶ Үүнээс үзвэл “*Арван хоёр зохионгуй*”-д буй тэрхүү ‘ваарчин’ гэдэг утга бүхий čayu:rayu:lči юм уу čaqurayulči гэдэг үг бидний судлагдахуунд холбогдохгүй өөр үг бололтой.

Дээр өгүүлсэн бүх баримт сэлтээс үзвэл хэрэглээ, илэрхийлэх утга хийгээд уг үг үүссэн байдал зэргийг эргэцүүлэн бодоход энэхүү ča’ur (< Мо. *√čayu+r), ča’ura- (< Мо. *√čayu+r+a-²⁷) гэдэг үг нь тухайн цагийнхаа нийгэмийн амьдрал, уугуул аж төрөлтэй гүнээ холбоотой учир монгол хэлний үндсэн үгийн санд багтах бөгөөд нийгэмийн шаардалгаар хожим бусад өөр хэлнээс авдаг тийм үгийн тоонд орохооргүй идэвхитэй хэрэглэгдэж байсан уугуул үг гэж үзэх бүрэн үндэстэй бөлгөө. Тэгээд ч монгол хүний нэрийн санд *Чаур*, *Чаурбэхи*, *Чаурхан*, *Чаурсээн* гэх зэрэг олон нэр “*Монголын нууц товчоон*”-оос аваад одоо хүртэл байгаа хэрэг.²⁸

1. 2. Зөрчид хэлний холбогдох баримт хэрэглэгдэхүүн:

Бид судлагдахуундаа шууд холбогдох зөрчид (女真 ~ 女眞 ~ 女直)²⁹ хэлний “*Nu-chen Hua-i I-yü*” (女真華夷譯語), “*Nu-chen Yi-yü*” (女真译语), “*Nu-chen Guan Za Zi*” (女真館雜字), “*Nu-chen Guan Lai Wen*” (女真館來文), “*Nu-chen kuan I-yü*” (女真館譯語) зэрэг үгсийн сангийн баримт болон “*Алтан Улсын судар*” зэрэг түүхэн сурвалж хэрэглэгдэхүүнийг тусхайлан судласан зөрчидөч Г. Н. Кийосэ (G. N. Kiyose)³⁰, [Чимэд]Дорж (道尔吉), Хэшиг (和希格)³¹, Жин Чи-чүн (金啓孫)³², А. М. Певнов³³ зэрэг олон эрдэмтэний судлагаанаас шүүрдэн үзвэл үгийн бүтэц болон утгын хувьд тохирох [盍] *čau язгуур бүхий [盍中] ‘цэрэг’ гэдэг үгийн хэлбэр гарч ирнэ. Чимэддорж профессор зөрчид хэлний энэхүү үгийн дуудалгыг *čauha

²⁵ D. Tumurtogoo, with the Collaboration of G. Cecegdari, *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script* (XIII-XIV centuries), Introduction, Transcription and Bibliography, Taipei, 2006, [722 pp.], See: pp. 109, 348.

²⁶ N. Poppe, *The Twelve Deeds of Buddha*, Seattle-Washington, 1967, [173 + plates 65 pp.], See: pp. 23, 113, 164, Plates p. 5

²⁷ Профессор И. де Рахевилз авгай “*Монголын нууц товчоон*”-ы дараагийнхаа судлагаанд уг үгийг čaurqa-čaurqa- хэмээн тэмдэглэжээ: Igor de Rachewiltz, *The Secret History of the Mongols*, Translation, Historical and Philological commentary, Vol. 1-2, Leiden-Boston, 2004, [pp. i-cxxvi + 6 + 1-642 + 643-1347], p. 1319.

²⁸ А. Дариймаа, *Монгол хүний нэрийн толь*, Улаанбаатар, 1986, [204 тал], 189-р тал.

²⁹ Ийнхүү ханзаар хэдэн өөр, тухайлбал: хятад болон хятан дураасхалд 2 - 3 янзаар тэмдэглэгдэгийн учир холбогдолыг дараахи номоос лавлана уу! G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, [260 pp.], p. 21; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичгийн товчоон*, Улаанбаатар, 2001, [300 тал], 249-р тал.

³⁰ G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, [260 pp.], See: pp. 74, 112, 114, 116[?!], 248.

³¹ 道尔吉, 和希格, 女真译语研究, - 内蒙古大学, 学报, (1983), 北京 [437 pp.], 73, 121.

³² 金啓孫, 冥僊卑佩咭 女真文辭典, 北京, 1984 年, [22 + 300 + 22 + 67 pp.], 248 p.

³³ А. М. Певнов, *Чтение чжурчжэньских писем*, Санкт-Петербург, 2004, [498 стр.], стр. 208, 350.

хэмээн тэмдэглээд уламаар *šooha* болсон гэж үзсэн³⁴ бол японы эрдэмтэн Х. Ямазу тэрхүү язгуурын дуудалга нь ерөөсөө *šoо* байсан гэж үзсэн байх бөлгөө.³⁵ Ямар ч атугай тэрхүү *šoо* нь манж хэлнээ бараг тэр хэвээрээ *šoоха* ‘цэрэг’ гэдэг үгэнд явж байгаа бөлгөө.

Г. Н. Кийосэ-гийн судлагаагаар зөрчид хэлнээ **šau* язгуураас гарсан дараахи үгийн хэлбэр буйг дураджээ³⁶:

[*𡗗*] **šau-ha* ‘army’;
[*𡗗* *𡗗* *𡗗* *𡗗*] **šau-ha e-je-hei* ‘military commission (gen.?)’

А. М. Певновын судлагаанаас үзэхүл зөрчид хэлнээ **šau* язгуур бүхий

[*𡗗*] **šau-ha* ‘цэрэг’
[*𡗗* *𡗗*(?)] **šau-shi* ‘цэрэг хэмээх үгийн олон тоот хэлбэр’;
[*𡗗* *𡗗* *𡗗*] **šau-la-mai*... ‘эзэн хааны буюу засагийн ордонь...’;
[*𡗗* *𡗗* *𡗗* *𡗗*(?)] **šau-la-mai-shi* ‘эзэн хааны буюу засагийн ордонь түшимэд’;
[*𡗗* *𡗗* *𡗗* *𡗗*] **šau-la-mai tiŋ* ‘эзэн хааны буюу засагийн ордонь хүрээ’

гэх зэрэг үг зөрчид сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байна.³⁷

Харин Жин Чи-чүн (金啓琮) профессор “Зөрчид хэлний толь”-доо дээрхи хоёр хэсэгт дурадсан жишээнээс гадна **šau* язгууртай

[*秀* *𡗗* *𡗗*(?)] **ge-en-šau-shi*;
[*𡗗* *𡗗* *𡗗*] **šau-ha nialma*;
[*𡗗* *𡗗* *𡗗* *𡗗*] **šau-ha nu-un*;
[*𡗗* *𡗗* *𡗗* *𡗗* *𡗗* *𡗗*] **šau-ha nu-un huan-di*
[*𡗗* *𡗗* *𡗗* *𡗗* *𡗗*] **šau-la-mai ti-in*

гэдэг өөр өөр баримтыг багтаажээ³⁸ (Тэмдэглэх учир: Энэ хэсэгт хавсаргасан латин галигийг нэгд, хэвлэлийн боломжоос шалтгаалан, хоёрт, бусад галигтай ойртуулсан тул Жин Чи-чүн авгайн толь дахи латин галигийн зарим тэмдэгт таарахгүй гэдэгийг толилуулая).

Зохиогч Жин Чи-чүн (金啓琮) авгай энэ бүтээлдээ оруулсан зөрчид хэлний үгсийн сангийн хэрэглэгдэхүүнээ холбогдох толь бичигийн хажуугаар “Алтан улсын судар” зэрэг бас бус эх сурвалжаас авсан учир тухайн үеийн ер энгийн бодат хэрэглээг харуулсанаараа онцгой чухал юм. Тийм ч учираас уг толийг үзэхэд тухайн үг хэлэлгийг хаана, ямар нөхцөлд, ямар үгтэй, хэрхэн хэрэглэгдэж байгааг давхар харж болно.

Тухайлбал: дээрхи жагсаалтад буй [*𡗗* *𡗗* *𡗗* *𡗗*] **šau-ha nu-un* гэдэг жишээ нь Зөрчидийн Алтан Улсын түүхэнд онцгой байр суурь эзлэж явсан Агуда (1068-1123) хааны нэрийн

³⁴ 道尔吉, 和希格, 女真译语研究, - 内蒙古大学, 学报, (1983), 北京 [437 pp.], 73.

³⁵ А. М. Певнов, *Чтение чжурчженьских писем*, Санкт-Петербург, 2004, [498 стр.], стр. 209.

³⁶ G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, [260 pp], See: pp. 74, 112, 114, 248.

³⁷ А. М. Певнов, *Чтение чжурчженьских писем*, Санкт-Петербург, 2004, [498 стр.], стр. 208-209.

³⁸ 金啓琮, 冥儼卑佩啮 女真文辞典, 北京, 1984 年, [22 + 300 + 22 + 67 pp.], 248.

тодотголд ордог, мөн [星虫] ‘эзэн хаан’ болон [金友余 ...] ‘эзэн хааны ордонь...’ гэдэг үгтэй шилжимэл утгаар хамт явж байгаа нь харагдана.³⁹ Энэ бүхэн нь мөнөөхи **šai* язгуур болон тэрхүү язгуураас үүссэн ‘*цэрэг*’ гэдэг утга бүхий **šai-ha* нь үлэмж хүндэдхэлтэй шилжимэл утга агуулах болж, тэгээд ч эзэн хааны нэр хийгээд эзэн хааны ордонь өмнө тодотхон ордог болохыг харуулж байгаа хэрэг биш үү? гэдэг бодол төрүүлж байна.

I. 3. Манж хэлний холбогдох баримт хэрэглэгдэхүүн:

Дээр өгүүлсэнчилэн ‘*цэрэг*’ гэдэг утга бүхий *šoоxa* хэмээх үг манж хэлэнд байдаг бөгөөд манжийн нөлөө үлэмж болсон үед бараг тэр хэвээрээ монгол хэлэнд орж, монгол хэлний утга нэг *цэрэг* гэдэг үгтэй хоршин *цэрэг цуух* хэмээн хэрэглэгдэх болсон билээ. Хэдий ийм боловч тухайн үгийн язгуур Алтай хэлний монгол, зөрчид, манж хэлнээ нийтлэг байсан учир холбогдолоор манжаас шууд орж ирсэн тэр үгийн Өвөг Алтай хэлэн дэхи уугуул язгуур, үндэсээс салбарлаж монгол хэлнээ хөгжисөн хэлбэр нь зэргэцэн байсаар ирсэн бөгөөд энэ өгүүлэлд чухамдаа тэр талаар ярьсан билээ. Үүнээс үүдэж, наад зах нь Алтай овогийн олон хэлний холбоо хэлхээний асуудалыг судлахдаа *язгуур гарал нэгтэй үг, хожим бие бидээ орсон үг ...* гэх зэргээр дотор нь 5 – 6 ангилаж, учир ялгавартай салгаж үзэх шаардалгатай байна хэмээн анхааруулсан профессор Р. Таш (R. Tas)–ийн саналыг энд дахин дурадхыг хүсэж байна.⁴⁰

I. 4. Нэгдүгээр хэсэгийг дүгнэвэл: Дээрхи олон баримт нь, *Ja’ud-quri ~ Ca’ud-quri* хэмээх цолын *Ja’ud- ~ Ca’ud-* гэдэг эхний үгийн *Ja’u- ~ Ca’u-* үндэс нь угтаа Өвөг Алтай (РА) хэлнээ нийтлэг байсан *довтло/x, дайри/x* гэсэн шууд утгатай, түүнээс *дайчин, эрэлхэг ...* гэсэн хийсвэр утга үүсч, уламаар тэрхүү хийсвэр утга нь цол болсон гэж үзэх боломжийг олгож байна. Үүнийг дээр өгүүлсэнчилэн, Алтан Улсын түүхэнд үлэмж үүрэг гүйцэдхэж, 1113 – 1115 онд зөрчидүүдийн удирдагч, уламаар 1115 оноос насан эцэс болголоо буюу 1123 он хүртэл хаан ширээнд суусан Тай-зү хаан Агуда-гийн нэрийн өмнөхи тодотхол давхар батлаж өгнө. Уг цолын яс утгыг монголоор яг тэгэж орчуулна гэсэн уламжлал байхгүй нь энэ хэр харамсалтай боловч орчин цагийн монгол хэлний “*цуу*” гэдэг үгтэй холбож үзэхэд болохгүй гэх газаргүй. Энэ мэтээр манай залуу үеийн алтайч, зөрчидөч эрдэмтэний хэн нэг нь зөрчид, хятад хэлээрхи эх сурвалжийг давхар харгалзан, наад зах нь “*Алтан Улсын түүх / судар*”-ын монгол орчуулгатай харьцуулан энэ цоорхойг нөхөх буй заа гэж итгэж байна. 1930 онд энэ сударыг Бат-очир шадар гуай манжаас орчуулсан есөн дэвтэр гарбичимэл нь Төв Номын Санд “*Алтан Улсын судар*” нэрээр буй, 1988 онд Дүдэн, Өлзийт нар хятадаас орчуулж “*Алтан Улсын түүх*” нэрээр Өвөр монгол газар монгол бичигээр хэвлүүлжээ.⁴¹

³⁹ 金啓祿, 冥饋申佩階 女真文辭典, 北京, 1984 年, [22 + 300 + 22 + 67 pp.], 248.

⁴⁰ Andras Róna-Tas, On the Meaning of “Altaic”, - Tractata Altaica, Wiesbaden, 1976, pp. 549-556; Ц.Шагдарсүрэн, Монгол хэлний хөгжлийн эрт үе, түүнийг судласан тойм, - Эртний монгол хэлний судлал (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи, I хэлмэли: Монгол хэл бичиг, II дэвтэр), Ulaanbaatar, 1999, (67-125), pp. 72-73; Ts. Shagdarśürüng, Problems of Methodology of Altaic Comparative Linguistics, - Rocznik Orientalistyczny, Tom. LVIII, Zeszyt I (Opera Altaistica professori Stanisłao Kalużyński octogenario dicata), Warszawa, 2005, pp. 179-187.

⁴¹ Altan ulus-un sudur, yisün debter, Manju kelen-eče Batuvčir orčiγulbai, Ulaγanbayatur, 1930 (Гар бичимэл); Altan ulus-un teike, Dūdeng, Öljeγitü nar orčiγulba, Begejing, 1988 [398 tal-a]

Иймэд РА. *√са+үи хэмээх үндэсээс үүссэн үг нь монгол, зөрчид, манж хэлнээ аль алинд нь өргөн хэрэглэгдэж, тус тусдаа салбарлан хөгжиж ирсэн Алтай овогийн уугуул үг хэмээн үзэх үндэс таамаг харагдаж байна. Үүнчилэн *алдар цуу* гэдэгийн *цуу* нь дээрхи язгуурын хийсвэр утгатай холбоотой эсэхийг магадлах шаардалга ч гарна.

Уг цолын эхиний хэсэг буюу *Ja'ud-* ~ *Ca'ud-* гэдэг үгийн талаар түрүүн гарсан судлагааг үзэхэд ганц удаа тохиолдож буй *Ja'ud* гэдэг хэлбэрийг цохон онцлож, хэдэнтээ гарч буй *Ca'ud* гэдэгээс илүүтэй анхаарсанаас арга буюу монгол бичигийн хэлний *jaγu(n)* гэдэг үгийн Дундад үеийн хэлбэр болох *ja'u(n)* гэдэг үгтэй холбож үзэхэд арга буюу хүрсэн⁴² байж болзошгүй, үүнд нь тухайн цол нэр монгол үг байсан байх гэсэн итгэл ч бас багагүй нөлөөлсөн буй заа. “*Монголын нууц товчоон*” болон “*Юан ши*” (元史 “*Yuan shih*”) хэмээх “*Юан Улсын судар*” зэрэг монгол үг, монгол нэрийг хятад үсэгээр галиглан бичсэн дурасхалд монгол үгийн нэг авиаг хэд хэдэн ханзаар тэмдэглэсэн байх нь үлэмжихэн харагддаг бөгөөд энэ талаар доктор Б. Сумьяабаатар тусхайлан өгүүлэл бичсэн нь буй.⁴³ Бас нэгэн баримт нэмэхэд: “*Юан ши*”-гийн уг эхэд монгол хүний нэр, зэрэг дэв гэх мэтийн хэдэн зуун монгол үгийн давтамжийг харахад нэг янзаар бичсэн зүйл бараг байдаггүй, тэгээд ч Тайбэй-д хэвлэсэн “*Юан ши*”-гийн 4-р дэвтэрт холбогдох бүх нэрийг жагсаан хавсаргахдаа тэдгээр ялгаатай тэмдэглэсэн хувилбаруудыг нэгэн дор багтааж монгол бичигээр давхар хадаж тодлосон байдаг билээ.⁴⁴

II. -quri хэмээх үгийн тухай

II. 0. “*Монголын нууц товчоон*”-ы 134, 179-р зүйлд гарч буй *Ja'ud-quri* ~ *Ca'ud-quri* хэмээх нэр – цолын *-quri* гэдэг хоёрдугаар бүрэлдүүлбэрийн тухай үүнээс өмнө нэг бус судлагч анхаарч өөр өөрийнхөө дүгнэлт саналаа бодолоо дэвшүүлжээ. Тэдгээр судлагааг ерөнхийд нь авч үзвэл дээр өгүүлсэнчилэн монгол хэлний үүднээс хандсан нь тодорхой харагдана.⁴⁵ Зөрчидийн Алтан улсаас өгсөн энэхүү *Ja'ud-quri* ~ *Ca'ud-quri* цолыг зөвхөн монгол хэлний үүднээс төдийгүй зөрчид, манж хэлтэй холбож үзэх нь учир зүйн хувьд илүү зохистой хэмээн үзэж байна.

II. 1. Зөрчид хэлний холбогдох хэрэглэгдэхүүн:

Юуны өмнө зөрчид хэлний толь бичигт “*Монголын нууц товчоон*”-дахи уг цолын хоёрдугаар бүрэлдүүлбэртэй дуудалгын хувьдтохирох (季) *xuri* гэдэг үг буй бөгөөд түүнийг хятадаар галиглан тэмдэглэсэн (忽里) ханз үсэг нь “*Монголын нууц товчоон*”-дахи *quri* гэдэг үгийг тэмдэглэсэнтэй адил байгаа⁴⁶ нь тухайн хоёр үг нэг болохыг харуулж байна уу даа гэж бодогдоно.

⁴² Хөх-өндөр, 札儿惕忽里 гэдэг үгэний утгын тухай, - Өвөр Монголын Нийгэмийн шинжлэх ухаан, 1993 оны нэгдүгээр хугацаа, No. 62, [87-91-р тал], 87-88-р тал (монгол бичигээр).

⁴³ Б. Сумьяабаатар, *Нууц товчооны нэг эхэд нэгэн монгол үгийг хэрхэн галигласан нь* - Acta Mongolica (Centre for Mongol Studies, National University of Mongolia), Volume VII (291), Ulaanbaatar, 2008, 79 - 112-р тал.

⁴⁴ *The History of Yuan Dynasty*, Vol. I-IV, - The Chinese Library (A Collection of Great Books of China), Published by The National War College in cooperation with the College of Chinese Culture, Editorial Board Chairman Dr. Chang Chi-yun, Taipei, 1966-1967 [Дөтүгээр богийн хавсралтад буй монгол нэрийн хэлхээг үзэх ажаамуу].

⁴⁵ Хөх-өндөр, 札儿惕忽里 гэдэг үгэний утгын тухай, - Өвөр Монголын Нийгэмийн шинжлэх ухаан, 1993 оны нэгдүгээр хугацаа, No. 62, 87-91-р тал.

⁴⁶ G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, [260 pp], See: pp. 104, 253; 道尔吉, 和希格, 女真译语研究, - 内蒙古大学, 学报, (1983), 北京 [437 pp.], 98, 228, 279; 金啓祿, 女真文辞典, 北京, 1984 年, [22 + 300 + 22 + 67 pp.], 14.

Зөрчид толь бичигт (𐰽) *xuri* гэдэг үгийг ‘*нарс модны үр*’ гэсэн шууд утгатай хэмээн тэмдэглэсэн⁴⁷ байх бөгөөд түүнийг Г. Н. Кийосэ англиар ‘*pine-cone*’ хэмээн орчуулжээ.⁴⁸

II. 2. Монгол хэлний үүднээс авч үзэх нь:

Үүнээс өмнө энэхүү үгийг тусхайлан авч үзсэн БНХАУ-ын эрдэмтэдийн судлагаатай танилцахад, “*Монголын нууц товчоон*” дахи уул нэрийн хоёрдугаар хэсэг болох (忽里) *xuri* хэмээх тэмдэглэгдэхүүний хажуугийн хадмал орчуулгад дулдуйдан, зөрчид хэлний утгы нь төдий л харгалзалгүй, монгол хэлний үүднээс авч үзээд ‘*хураа/х, хори/х, хори*’ гэх зэрэг монгол үгтэй холбон тайлбарласан байх ажээ. Хөх-өндөр авгай тэдгээр судлагааг нэгэдхэн авч үзээд өөрийн саналаа дэвшүүлжээ. Тухайлбал: Хөх-өндөр авгай Баруун Тоба Вэй улсын үед байсан дөрвөн зэрэг дэв бүхий ‘*хори*’ цол болон “*Монголын нууц товчоон*”-ы ‘*ноён*’ гэдэг үгтэй холбон үзээд *Ja’ud-quri* ~ *Ca’ud-quri* хэмээх цол нэр нь ‘*зуудын ноён*’ гэсэн утгатай үг гэж бодож байна хэмээжүхүй.⁴⁹

“*Монгол үгэсийн язгуурын толь*”-доо Сэцэнцогт авгай монгол хэлний ‘*хори/х, хаши/х, хотло/х, хуми/х ...*’ гэсэн утга бүхий *qori-* хэмээх язгуурын тайлбартаа “...*зорчин*⁵⁰-өөр бас « хэги » *гэнэ*” гэж тэмдэглэжээ.⁵¹ Толийн зохиогч оршилдоо манж хэлний “*чооха*” гэдэг үгийг монгол хэлний “*црэг*” гэдэг үгтэй гаралын хувьд “...*язгуур нэг байж мэднэ...*” хэмээн тэмдэглэнгээ алтай овогийн хэлнүүдэд утгын ороноороо холбоотой олон үг байдагийг дурадсан нь буй.⁵² Утгазүйн үүднээс энэ үгийг монгол хэлний ‘*цугла/х*’ гэсэн утга бүхий, “*Чингисийн чулууны бичиг*”, “*Монголын нууц товчоон*”-ы 164, 245-р зүйл, “*Сулхарнайн түэж*” болон бас бус сурвалжид⁵³ тэр утгаараа нэг бус удаа хэрэглэгдэж ирсэн *quri-*, *quri/qu*, *quri/m* гэх зэрэг *quri-* үндэст үгтэй түүхэн холбоогүй гэхэд бас бэрх.

Монгол хэлнээ *хурил* (< Мо. *quril*) гэдэг үг буй бөгөөд энэ нь “*хэрэмний оришх үүр газар*”-ыг хэлдэг хэмээн тайлбар тольд тэмдэглэжээ.⁵⁴ Хэдийгээр энэ хэр шууд холбох баримт үгүй ч, *хэрэм самар иддэг, самар хураадаг* гэх зэргээр самартай холбоотойг бодолцох бөгөөс дээр өгүүлсэнчилэн зөрчид хэлний (𐰽) *xuri* гэдэг үгийн ‘*нарс модны үр, шогшогой*’ гэсэн шууд болон түүнээс салбарласан шилжимэл утгатай огт холбоогүй гэж батлах аргагүй. Монгол Улсын Их Сургуулийн багш манжич М. Баярсайхан үүнтэй санал хуваалцаж байна.

⁴⁷ 金啓葆, 冥曠卑佩嗜 女真文辞典, 北京, 1984 年, [22 + 300 + 22 + 67 pp.], 14, ++ 35.

⁴⁸ G.N. Kiyose, *A Study of the Jurchen Language and Script*, Kyoto, 1977, [260 pp.], See: pp. 104.

⁴⁹ Хөх-өндөр, 札儿惕忽里 гэдэг үгэний утгын тухай, - Өвөр Монголын Нийгэмийн шинжлэх ухаан, 1993 оны нэгдүгээр хугацаа, No. 62, [87-91-р тал], 90-р тал.

⁵⁰ *Зөрчин, зөрчид* гэдэг хоёр хэлбэр буй. Монголчуудын түүхэн баримтад *зөрчид* гэдэг хэлбэр түлхүү харагддаг нь санамсаргүй буюу буруу хэлбэр огт биш. Монгол хэлнээ *дархад, оолүд, дөрвөд, баяд, олхонуд, жаруд* гэх зэргээр овог, угсаатаны нэрд бөлөг олоны утгатай –д дагавар залгадаг түгээмэл онцлогтой. Тэрчилэн *тангуд* гэдэг харь нэрийн –уд дагаварыг монгол хэлний нөлөө гэж тангудач эрдэмтэн Н. А. Невский тэмдэглэсэн байдаг бөлгөө. Энэ талаар дараахи номоос [Н. А. Невский, *Тангутская филология*, Книга 1, Москва, 1960, стр. 74; Ц. Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичигийн товчоон*, Улаанбаатар, 2001, 265 – 266-р тал] тодруулан үзнэ үү.

⁵¹ Secenčoytu, *Mongyol üges-ün ijayur-un toli*, Kökeqota, 1987, [2974], 1103.

⁵² Secenčoytu, *Mongyol üges-ün ijayur-un toli*, Kökeqota, 1987, [2974], 4-5.

⁵³ Secenčoytu, *Mongyol üges-ün ijayur-un toli*, Kökeqota, 1987, [2974], 1143.

⁵⁴ Я. Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 1966, 733. а.

Ерөнхий дүгнэлт таамаг: Дээрхи хоёр хэсэгт өгүүлсэн зүйлийг нэгэдхэн дүгнэж үзвэл Зөрчидийн Алтан Улсаас өгсөн гэх *Ja'ud-quri ~ Ca'ud-quri* гэдэг цол нь Өвөг Алтай хэлний уугуул үг бөгөөд түүнээс монгол, зөрчид, манж хэлнээ зэргэцэн салбарлаж, өөр өөрийнхөө жам хуулиар хөгжихдөө аль алинд нь шилжисэн утга буй болсон, тэгээд ч зөрчид хэлнээ хийсвэр утгатай болсон *Ja'ud-quri ~ Ca'u-quri* гэдэг хэлбэр нь цэрэгийн гавъяа зүтгэлтэнийг хөхиүлэн шагнаж олгодог цол нэр болсон гэж үзэх үндэс таамаглал гарч байна. Хойч үеийн залуу судлагч нар нэгэн гарчигийн дор нэгэдхэн багцласан дээрхи баримт сэлтийг минь харгалзан, Зөрчидийн түүхийн сурвалжтай нарийвчилан танилцаж, зөрчид хэлний хэрэглэгдэхүүнийг манж болон Алтай овогийн бусад хэл аялгууны холбогдох баримт сэлт хийгээд тэдгээрийн хятад орчуулга, тайлбар сэлттэй нь тулган нягтлаж лавшируулан судлахын хэрээр бидний санал таамагийн зөв эсэх нь улам тодорхой болно хэмээн найдаж байна.